

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын
11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт
цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2025 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	БиДиСЕК ҮЦК ХК 9010001030 522 7555-1919, 99210566	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	- Андеррайтер, брокер, дилерийн үйл ажиллагаа - Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа - Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах - Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/ - Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Panther Midland Audit LLC	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	13,694,883 ширхэг	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Б. Хулан /Мэдээллийн ажилтан/ Хянасан: Б.Лхагвадорж /Гүйцэтгэх захирал/	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав. /Хавсралт №1/
	Орлогын тайлан	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	
	Мөнгөн гүйлгээний тайлан	

1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>		
	Panther Midland Audit LLC нь эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна. Тайланг хавсралтаар оруулсан.		
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>		
	Аудитын дүгнэлтийг хавсаргав.		
2.	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгссөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>		
2.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	18.50%
		Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	33.10%
		Нэгж хувьцааны өгөөж /EPS/	730.65
		Үнэ ашгийн харьцаа (P/E Ratio)	2.19
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Ашигт ажиллагаа	57%
		Эргэлтийн харьцаа	8.70
		Санхүүгийн хөшүүрэг	2.56
		Өр төлбөр, хөрөнгийн харьцаа	0.44
		Хөрөнгийн зохистой харьцаа /андеррайтерийн компанийн хувьд/	93.75
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i> Брокерийн үйл ажиллагаа 2025 оны жилийн эцсийн байдлаар компани брокерийн үйл ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын нийт 1,231 үнэт цаасны данс нээж, харилцагчийн бааз суурийг нэмэгдүүлэв. Мөн түүнчлэн МХБ-ийн арилжаанаас гадна Биржийн Бус Зах Зээлийн арилжааны хэмжээ, хөрөнгө оруулагчдын тоо тогтмол нэмэгдсээр байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар БЕЗЗ-р дамжуулан нийт 37.7 тэрбум төгрөгийн арилжааг гүйцэтгэсэн байна. Мөн МХБ дээр арилжаалагдаж буй Засгийн Газрын Үнэт Цаасны арилжаанд оролцож нийт 42.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Мөн МХБ дээр арилжаалагдаж буй Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцон 265.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.		

		Жилийн эцсийн байдлаар “БиДиСЕК ҮЦК” ХК нь МХБ дээр хийгдсэн нийт арилжааны 102.7 тэрбум төгрөгийн арилжааг дангаар гүйцэтгээд байна. - Андеррайтерийн үйл ажиллагаа “БиДиСЕК ҮЦК” ХК нь андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд • “Амилагийн хүүхдүүд цэцэрлэг”-ээс гаргаж буй бонд болох Амила Бондыг ББЗЗ-д санал болгон арилжаалж 5 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэв. • “Дорнын их гэгээ” ХХК-иас гаргаж буй бонд болох DIG бондыг ББЗЗ-д санал болгон ББЗЗ дээр транч 1ийн хүрээнд 4 тэрбум төгрөг, транч 2-ын хүрээнд 2 тэрбум төгрөг, транч 3-ын хүрээнд 1.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлэв. • “Цогц Зээл ББСБ” ХХК-иас гаргаж буй бонд болох TSOГ бондыг ББЗЗ-д санал болгон арилжаалж 1.3 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэв. • “Таун констракшн” ХХК-иас гаргаж буй бонд болох TOWN бондыг ББЗЗ-д санал болгон арилжаалж 6.5 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэв. Мөн тайлант хугацаанд нийт 4 төслийн судалгааны түвшинд ажиллаж, дараагийн хамтран ажиллах боломжтой төслүүдийг товлон, бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажиллаж байна. - Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ Компани нь зөвлөх үйлчилгээний хүрээнд “Монголын Хөрөнгийн Бирж” ХК “ХААН Банк” ХК, “АНУ” ХК, “Бодь Даатгал” ХК, “Тавантолгой” ХК гэх мэт нийт 16 нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг биетээр болон цахимаар зохион байгуулах, зөвлөмж өгөх, санал авах, тогтоол шийдвэрийн төслүүдийг боловсруулж хамтран ажиллав. Мөн хувьцаат компанийн ээлжит болон ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайнаар зохион байгуулах www.agm.mn системийн шинэчлэн сайжруулалтын хүрээнд стресс тестийг гүйцэтгэж эмзэг байдлыг засварлах, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, зарим функцуудыг засварлах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	- Тайлант хугацаанд тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	-

3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/
----	--

Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байхгүй

4.Цалин урамишууллын мэдээлэл

Тайланг хавсаргав

5.Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

2008 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр АНУ, Турк, Япон улсын нэр бүхий томоохон компаниудын удирдлага, хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид сонгогдсон бөгөөд одоогийн байдлаар 4 хараат бус гишүүнтэйгээр компанийн засаглалын зохистой харьцааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй ба 1 жилийн бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн ТУЗ-ийн гишүүд нь 2025 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдон ажиллаж байна.

№	Нэр	Албан тушаал	ТУЗ дэх албан тушаал	Засаглалын гэрчилгээний дугаар	ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж буй хувьцааны тоо
1	Д.Даянбилгүүн	БиДиСЕК ҮЦК ХК-ийн Ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга	ТУЗ-ийн дарга	0420034	2,380,210
2	Б.Лхагвадорж	БиДиСЕК ҮЦК ХК-ийн гүйцэтгэх захирал	Ердийн гишүүн	0420027	465,436
3	Н.Батгэрэл	БиДиСЕК ҮЦК ХК-ийн дэд захирал	Ердийн гишүүн	00048	328,014
4	Utuc Bingol	Импера Капитал Дэд захирал	Ердийн гишүүн	0430584	0
5	О.Уранбайгал	БиДиСЕК ҮЦК ХК-ийн Back office department, Vice President	Ердийн гишүүн	0430673	881
6	Хитоши Тани	Эгзэ Группийн Ерөнхийлөгч	Хараат бус гишүүн	0420036	0
7	М.Туяа	“Шилдэг” сургууль, Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга	Хараат бус гишүүн	0431250	2,572
8	Д.Амгаланбаяр	MSM ХХК, захиргааны мэргэжилтэн	Хараат бус гишүүн	0430105	332,129
9	Б.Энхбаяр	Санаа Эгзэ ХХК-ийн гүйцэтгэх захирал	Хараат бус гишүүн	0520013	100

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх түр хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон. Үүнд:

Нэр дэвшүүлэх дэд хороо:

Дарга:	М.Туяа	Хараат бус гишүүн
Гишүүд:	Б.Лхагвадорж	Ердийн гишүүн

	Улуч Бингол	Ердийн гишүүн	
Аудитын хороо:			
Дарга:	Д.Амгаланбаяр	Хараат бус гишүүн	
Гишүүд:	М.Туяа	Хараат бус гишүүн	
	О.Уранбайгал	Ердийн гишүүн	
Цалин урамшууллын хороо:			
Дарга:	Б.Энхбаяр	Хараат бус гишүүн	
Гишүүд:	Хитоши Тани	Хараат бус гишүүн	
	Н.Батгэрэл	Ердийн гишүүн	
Компанийн гүйцэтгэх удирдлагын мэдээлэл:			
№	Нэр	Албан тушаал	Компанид ажилласан жил
1	Б.Лхагвадорж	БиДиСЕК ҮЦК ХК-ийн Гүйцэтгэх захирал	27
2	Н.Батгэрэл	БиДиСЕК ҮЦК ХК-ийн Тэргүүн дэд захирал	27
3	Б.Онон	БиДиСЕК ҮЦК ХК-ийн Арилжаа хариуцсан дэд захирал	7
4	О.Уранбайгал	Back office алба, Vice President	16
5	С.Дамдинсүрэн	IT алба, Director	16
6	С.Дөлгөөн	Хөрөнгө оруулалтын алба, Vice Director	7
7	Б.Пүрэвсүрэн	Дотоод албаны менежер	27
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл		
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/		
Компанийн 5-с дээш хувь эзэмшигчдийн /нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид/ мэдээлэл:			
№	Нэр	Эзэмшлийн хувь	
1	Zwahr Alexander	25.34%	
2	Д.Даянбилгүүн	17.38%	
3	Тасган Инвест ХХК	17.21%	
4	Монголиан Мастер Менежмент ХХК	9.66%	
5	Импера Монголиа Холдинг ЛТД	6.20%	
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл		
9.	Ногдол ашгийн мэдээлэл		
Компани нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнг харгалзан нийт 1,941,236,280.48 төгрөгийг хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 141.75 (нэг зуун дөчин нэгэн төгрөг далан таван мөнгө) төгрөгөөр тооцож ногдол ашиг хуваарилна.			
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл		
Тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын хүрээнд: Компаниас Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч нарын дунд уламжлал болон зохнон байгуулагддаг BDScip хөл бөмбөгийн тэмцээнд 18 дахь удаагаа 2025 оны 9 сарын 20-нд амжилттай болж өндөрлөсөн.			

	BDSCap хөл бөмбөгийн 18 дахь удаагийн тэмцээнд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв, БиДиСЕК ҮЦК ХК, Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв, Монголын Арилжаа Эрхлэгчдийн Холбоо, Апекс капитал ҮЦК, Гүүдсек ҮЦК, Голомт Капитал ҮЦК-ийн нийт 8 багийн 80 гаруй тамирс
--	---

МХБ Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн
47 дугаар тогтоолын хавсралт
“Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн
журам”


11.	Үнэт цаас гаргагчийн бүтэц (толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар), холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;
	BDCAP ХХК нь БиДиСЕК ҮЦК ХК-ийн 100% эзэмшлийн охин компани юм. Холбоотой санхүүгийн гүйлгээний талаарх мэдээллийг хавсралтаарх аудитлагдсан санхүүгийн тайлан балансад тусгаж өгсөн.
12.	Үнэт цаас гаргагч нь (Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, болон Үнэт цаасны компани) төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
	Хөрөнгийн зохистой харьцаа 93.75 Төлбөрийн чадварын харьцаа 8.7
13.	Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах, компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэх, компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болох нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл
	Зардал бууруулах, төсөв шинэчлэх, ашигтай орлогын секторуудад анхаарах, өглөг цуглуулах, борлуулагдаж болох хөрөнгө борлуулах , шинэ хөрөнгө оруулалт нэмж капитал нэмэх
14.	Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл
	Тайлант хугацаанд компани нь хувьцаагаа эргүүлэн худалдан авах, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэт цаасаар урамшуулал олгосон тохиолдол байхгүй болно.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:


Овог, нэр: Б.Лхагвадорж

Албан тушаал: "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)




Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Хулан

Албан тушаал: "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Мэдээллийн ажилтан

Гарын үсэг:





“ПАНТЕР МИДЛАНД АУДИТ” ХХК

“БИ ДИ СЕК ҮЦК” ХК

**2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар
болгосон аудитын тайлан**

Улаанбаатар хот

2026 он



"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу

Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг
Утас: 976-7013-1770
Гар утас: 9511-1770

Аудитор Ц.Алтанцэцэг
Гар утас: 95111770
Туслах аудитор Ш.Бямбаа
Гар утас: 97111770

Чанарын хяналтын аудитор
Б.Сансармаа
Гар утас: 91006906

Аудиторын туслах Э.Мөнгөннавч
Н.Гэрэлцэцэг

"Пантер мидланд аудит" ХХК
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо,
ЗКомпьютер молл 1101 тоот
e-mail: info@pma.mn
fax: 976-7014-1770

Вэб хуудас: www.pma.mn

2026 оны 02 дугаар сарын 27

АГУУЛГА

ХУУДАС

Хараат бус аудиторын тайлан	2-4
Санхүүгийн байдлын тайлан	5
Орлогын тайлан	6
Мөнгөн гүйлгээний тайлан	7
Өмчийн өөрчлөлтийн тайлан	8
Санхүүгийн тайлангийн тодруулга, компанийн товч мэдээлэл, танилцуулга	9-10
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй	11-17
Санхүүгийн тайлангийн тодруулга	18-28
Залруулагдсан санхүүгийн тайлан.....	29

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2026.02.24

№ 26/04.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН УДИРИДЛАГАД

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид "Би Дек Сек ҮЦК" ХК (Компани гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 9-30 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа, тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах, компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцсан.

Номинал дансны талаар

"Би Ди СеК ҮЦК" ХК нь өөрийн нэр дээр Голомт банкин дах 1105057130 тоот төгрөгийн данс, 1105391344 тоот ам. долларын данс, Худалдаа хөгжлийн банкин дах 452644001 тоот ам.долларын, 452643141 тоот төгрөгийн, Богд банкинд дах 8160011183 тоот, Төрийн банк дах 343100276403 тоот төгрөгийн, Тээвэр хөгжлийн банк дах 90000109635 тоот, 9000092505 тоот төгрөгийн дансаар тус тус дамжуулан өөрийн харилцагчдын МХБ-н арилжааны хэлцлээс үүдэлтэй төлбөр тооцоог валют тус бүрээр ялган гүйцэтгэсэн байна.

Ингэхдээ Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-н 6.2.8. болон 6.2.9 шаардлагуудыг тус тус ханган ажиллаж, холбогдох хууль тогтоомжид заасан зохицуулалтыг мөрдөн ажиллаж байгаа нь гүйлгээний баримт, харилцагчийн арилжааны захиалгын гэрээ зэрэг анхан шатны баримтуудаар нотлогдож байна.

Тус журмын 6.2.5.-д заасны дагуу компани нь харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан, балансын гадуур бүртгэж, өөрийн эргэлтийн хөрөнгө болон, өөрийн хөрөнгийн зохист харьцаанд хамааруулан тооцдоггүй нь компанийн санхүүгийн байдлын тайлангаас харагдаж байна.

Харилцагчдын нэр дээр хийгдсэн орлого болон зарлага, арилжааны хэлцэлтэй холбоотой мөнгөн гүйлгээний мэдээллийг дэлгэрэнгүй хөтөлж, бүртгэлд үнэн зөв тусгасан бөгөөд холбогдох зохицуулалтын хүрээнд харилцагчдын гүйлгээтэй холбоотой дэлгэрэнгүй тайланг сар тус бүрээр гарган, зохицуулагч байгууллагуудад хүргэн ажилласан байна.

Бид аудитын горимын дагуу дээрх арилжааны банкинд байрших номинал дансанд аудитын горимын дагуу тулган баталгаажуулалтыг хийхэд ямар нэгэн алдаа зөрчил гараагүй болно.

Компани нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" хуулийн 4.1.-т заасан "Мэдээлэх үүрэгтэй этгээд"-ийн хүлээсэн үүргийн хүрээнд номинал дансаар дамжин харилцагчдын дансанд хийгдсэн их дүнтэй гүйлгээний мэдээллийг Монгол Банк болон Санхүүгийн Зохицуулах Хороонд тухай бүр болон улирал тутамд тогтмол цахим болон цаасан хэлбэрээр тайланг хүргүүлэн ажилласан байна.

"Би Ди Сек ҮЦК" ХК-ний харилцагчдын арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах зорилго бүхий номинал дансны харилцагчийн мөнгөн гүйлгээний тайланг банкны хуулга болон анхан шатны баримт, мөнгөн хөрөнгө дамжсан данс бүрээр нь тулган шалгахад Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам", байгууллагын "Харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, гүйлгээний журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хөтөлсөн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,965,040,323.92	6,907,328,407.59
Дансны авлага	2,775,600,425.50	3,123,767,838.13
Бусад авлага	358,796,455.66	609,893,609.27
Санхүүгийн хөрөнгө	5,069,044,413.61	7,626,180,758.71
Бараа материал	23,356,071,861.86	32,105,175,813.41
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	759,208.46	389,867.80
Эргэлтийн хөрөнгийн дүн	36,525,312,689.01	50,372,736,294.91
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,439,351,644.90	4,299,340,656.96
Биет бус хөрөнгө	16,766,267.37	3,953,210.77
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,456,117,912.27	4,303,293,867.73
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	40,981,430,601.28	54,676,030,162.64
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	140,167,474.34	395,000,913.73
Цалингийн өглөг	80,561,590.10	0.00
Татварын өр	82,213,964.78	285,253,749.78
НДШ-ийн өглөг	36,064,140.12	44,332,651.62
Богино хугацаат зээл	0.00	2,478,762,202.66
Хүүгийн өглөг	473,767,106.85	497,374,850.00
Ногдол ашгийн өглөг	0.00	57,374,539.25
Нөөц/өр төлбөр/	41,084,649.00	41,084,649.00
Бусад богино хугацаат өр төлбөр	1,346,545,320.30	3,291,370,088.56
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,200,404,245.49	7,090,553,644.60
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	17,322,795,510.05	18,125,095,510.05
Бусад урт хугацаат өр төлбөр	2,535,395.78	2,535,395.78
Урт хугацаат өр төлбөрийн дүн	17,325,330,905.83	18,127,630,905.83
Өр төлбөрийн нийт дүн	19,525,735,151.32	25,218,184,550.43
Эздийн өмч		
Өмч: - төрийн	0.00	0.00
- хувийн	9,326,763,118.32	9,326,763,118.32
Нэмж төлөгдсөн капитал	34,472.68	34,472.68
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,821,437,107.82	3,821,437,107.82
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	8,307,460,751.14	16,309,610,913.39
Эздийн өмчийн дүн	21,455,695,449.96	29,457,845,612.21
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	40,981,430,601.28	54,676,030,162.64

9-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	5,230,097,597.19	15,026,138,886.48
Брокер диллерийн үйл ажиллагааны орлого	2,192,718,674.33	1,428,675,281.60
Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	403,441,096.55	651,000,000.00
Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	1,321,984,554.36	6,967,844,203.88
Бондын хүү арилжааны орлого	1,311,953,271.95	0.00
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	0.00	5,978,619,401.00
Түрээсийн орлого	0.00	0.00
Хүүний орлого	382,154,000.10	751,609,060.26
Ногдол ашгийн орлого	1,025,870,120.75	1,095,014,183.59
Хувцааны ногдол ашиг	1,025,870,120.75	1,095,014,183.59
Хараат болон хамтаран компаниас олсон ашиг	0.00	0.00
Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
Бусад орлого	51,576,207.39	866,734,427.76
Борлуулалт маркетингийн зардал	0.00	1,200,319,041.87
Ерөнхий ба удирдлагын зардал	1,930,101,696.36	5,938,503,065.72
Санхүүгийн зардал	2,503,632,015.44	587,828.62
Бусад зардал	48,879,429.09	26,000,000.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,497,456,411.81	(828,506,472.30)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	34,340,911.46	0.00
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,390,000.00	0.00
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,740,272,107.81	9,745,580,149.58
Орлогын татварын зардал	199,633,218.34	515,409,828.72
Татварын дараах ашиг (алдагдал)	6,540,638,889.47	9,230,170,320.86
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,540,638,889.47	9,230,170,320.86
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)	0.00	0.00
Орлогын нийт дүн	6,540,638,889.47	9,230,170,320.86

9-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,326,763,118.32	0.00	3,821,437,107.82	8,307,460,751.14	21,455,660,977.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	9,326,763,118.32	34,472.68	3,821,437,107.82	8,307,460,751.14	21,455,695,449.96
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,326,763,118.32	34,472.68	3,821,437,107.82	8,307,460,751.14	21,455,695,449.96
Залруулсан үлдэгдэл	9,326,763,118.32	34,472.68	3,821,437,107.82	8,307,460,751.14	21,455,695,449.96
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	9,230,170,320.86	9,230,170,320.86
Ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(1,228,020,158.61)	(1,228,020,158.61)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,326,763,118.32	34,472.68	3,821,437,107.82	16,309,610,913.39	29,457,845,612.21

9-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салцгүй хэсэг мөн.

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	4,236,616,183.97	16,360,909,767.10
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,472,739,856.75	7,260,150,401.97
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,652,377.00	10,961,274.00
Буцаан авсан албан татвар	0.00	9,404,663.91
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	6,691,601,523.70
Хүлээн авсан хүүний орлого	0.00	1,186,091,752.47
Хүлээн авсан ногдол ашиг	0.00	1,091,566,356.44
Бусад мөнгөн орлого	760,223,950.22	111,133,794.61
Мөнгөн зарлагын дүн (-)	12,742,645,381.97	15,547,344,024.49
Ажилчдад төлсөн	1,236,376,875.02	1,659,098,445.20
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	356,427,371.51	412,306,807.30
Бараа материал худалдан авахад төлсөн	6,443,500,000.00	9,588,572,168.24
Ашиглалтын зардалд төлсөн	88,024,902.17	9,137,042.09
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	37,706,935.00	30,999,668.17
Хүүний төлбөрт төлсөн	2,037,048,383.93	2,138,044,939.38
Татварын байгууллагад төлсөн	247,534,474.10	476,154,081.55
Даатгалын төлбөрт төлсөн	12,552,767.00	10,137,783.00
Зохицуулалтын хөлс, шимтгэл, хураамжинд төлсөн	282,870,012.23	0.00
Бусад мөнгөн зарлага	2,000,603,661.01	1,222,893,089.56
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,506,029,198.00)	813,565,742.61
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	16,991,082,189.35	1,838,931,949.89
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	75,390,000.00	0.00
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	12,751,409,852.23	0.00
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,508,381,711.70	1,838,931,949.89
Хүлээн авсан хүүний орлого	1,686,333,950.01	0.00
Хүлээн авсан ногдол ашиг	969,566,675.41	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	3,418,474,333.72	2,975,119,212.41
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	52,823,280.00	21,673,337.20
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	134,080,000.00	0.00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	3,231,571,053.72	2,953,445,875.21
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	13,572,607,855.63	(1,136,187,262.52)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	155,746,143,738.91	45,861,471,946.23
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	6,850,252,208.89	15,048,395,025.68
Төрөл бүрийн хандив	(2,149,000.00)	(6,000,000.00)
Бусад мөнгөн орлого	148,898,040,530.02	30,819,076,920.55
Мөнгөн зарлагын дүн (-)	158,737,587,503.00	43,570,192,611.46
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	11,236,875,709.82	11,225,417,099.52
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	5,081,373,385.87	427,515,874.62
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0.00	0.00
Төлсөн ногдол ашиг	412,640,813.43	1,096,425,552.25
Ханшийн тэгшитгэлийн алдагдал		0.00
Бусад мөнгөн зарлага	142,006,697,593.88	30,820,834,085.07
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(2,991,443,764.09)	2,291,279,334.77
Валютын ханшийн зөрүү	(3,799,754.05)	(26,369,731.19)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,071,335,139.49	1,942,288,083.67
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,893,705,184.43	4,965,040,323.92
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,965,040,323.92	6,907,328,407.59

9-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.

НЭГ. "БИ ДИ СЕК ҮЦК" ХК-НИЙ 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Эдгээр тэмдэглэлүүд нь өмнөх санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-НИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- *Байршил:* Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 "Би Ди Сек ҮЦК" ХК-ний байр Утас1: 976-11-313196, 313108 И-мэйл: info@bdses.mn
- *Өмчийн хэлбэр:* Хувьцаат Компани
- *Харилцдаг санхүү, татварын байгууллага:* Чингэлтэй дүүргийн төрийн сан, татварын хэлтэс
- *Тайлангийн хугацаа:* 2025 оны 01 сарын 01-нээс 2025 оны 12 сарын 31
- *Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*
 - ✓ Брокер, дилерийн
 - ✓ Андеррайтерийн
 - ✓ Хөрөнгө оруулалтын зөвлөх
 - ✓ Гадаад улсын үнэт цаасын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа
- ✓ *Аудитор:* "Пантер Мидлан Аудит" ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо Комьютер молл байр 1101 тоот Утас: 70141770, 95111770, 97111770

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-НИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Би Ди Сек ҮЦК" ХК нь анх 1991 онд "Баяндөхөм" нэртэйгээр Төв аймгийн Зуунмод хотод иргэдийн өмч хувьчлалын тасалбарыг бүртгэх, бичилт хийх ажлыг зохион байгуулах зорилгоор байгуулагдсан. Улсын бүртгэлээс 9010001030 дугаартай, 2052482 тоот регистрийн дугаар бүхий гэрчилгээг авч хөрөнгийн зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах зорилгоор "Би Ди Сек ҮЦК" ХК болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан байна.

"Би Ди Сек ҮЦК" хувьцаат компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд Монгол улсад Хөрөнгийн зах зээл үүссэн 1991 оноос хойш тасралтгүй 30 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар дараах төрлийн үйл ажиллагааг явуулж байна.

- Брокер, дилерийн
- Андеррайтерийн
- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн
- Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа.

2007 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайг "Би Ди Пи И Эф" ХХК-ийг хөрөнгө оруулалтын чиглэлээр үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2007 оны 8-р сарын 15-нд 5157781 регистр бүхий 901117032 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

Тус компани нь дараах 4 салбартай. 2 салбар үйл ажиллагаа нь идэвхитэй явагддаг.

1	Орхон аймаг салбар	Орхон аймаг Хүрэн булаг сум, Харх ХХК-ний байр 205 тоот
2	Дархан аймаг салбар	Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг, Дархан их дэлгүүрийн 6 давхарт, 604 тоот

2007 оны 9-р сарын 14-нд "Би Ди Пи И Эф" ХХК-ийн нэрийг "Би Ди Си Эй Пи" ХХК болгон өөрчилсөн. "Би Ди Си Эй Пи" ХХК нь үл хөдлөх хөрөнгийг бусдад түрээслүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг.

2015 оны 12 сарын 03-нд гадаад худалдааны чиглэлээр байгуулсан 6025862 регистр бүхий 9011577076 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Их Чингис хааны хөмрөг" ХХК-ийг 2019 оны 02 сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн тогтоолоор хөрөнгө оруулалтын менежментийн компани болгон өөрчлөн байгуулж 100,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Гол томоохон хувь нийлүүлэгчид

Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувь
Монголиан мастер менежмент ХХК	8.87%
Тасган инвест ХХК	15.32%
Д.Даянбилгүүн	17.45%
Zwahr Alexander	24.73%
Импера Монголиа Холдинг	6.25%
Нийт	

2008 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр АНУ, Турк, Япон улсын нэр бүхий томоохон компаниудын удирдлага, хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид сонгогдсон бөгөөд одоогийн байдлаар 4 хараат бус гишүүнтэйгээр компанийн засаглалын зохистой харьцааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй ба 1 жилийн бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн ТУЗ-ийн гишүүд нь 2024 оны 04 сарын 02-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл:

№	Нэр	Албан тушаал	ТУЗ дэх албан тушаал	Засаглалын гэрчилгээний дугаар	ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж буй хувьцааны тоо
1	Д.Даянбилгүүн	БиДиСЕК ҮЦК ХК-ийн	ТУЗ-ийн	420034	465,436
2	Б.Лхагвадорж	БиДиСЕК ҮЦК ХК-ийн гүйцэтгэх захирал	Ердийн гишүүн	420027	2,377,150
3	Н.Батгэрэл	БиДиСЕК ҮЦК ХК-ийн дэд захирал	Ердийн гишүүн	48	338,014
4	Uluc Bingol	Импера Капитал Дэд захирал	Ердийн гишүүн	430584	-
5	О.Уранбайгал	БиДиСЕК ҮЦК ХК-ийн, Back office department	Ердийн гишүүн	430673	881
6	Хитоши Тани	Эгзэ Группийн ерөнхийлөгч	Хараат бус гишүүн	420036	-
7	М.Туяа	"Шилдэг" сургууль, үүсгэж байгуулагч, ТУЗ-ын дарга	Хараат бус гишүүн	-	-
8	Д.Амгаланбаяр	MSM ХХК, захиргааны мэргэжилтэн	Хараат бус гишүүн	430105	332,129
9	Б.Энхбаяр	Санаа Эгзэ ХХК-ийн гүйцэтгэх захирал	Хараат бус гишүүн	520013	100

Гүйцэтгэх удирдлага:

Б.Лхагвадорж	"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн гүйцэтгэх захирал
Н.Батгэрэл	"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн тэргүүн дэд захирал
Б.Оюун	"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн арилжаа хариуцсан дэд захирал

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь зөвхөн "Би Ди Сек ҮЦК" ХК-ийнх бөгөөд тоон мэдээллүүд нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг /MNT/-өөр илэрхийлэгдсэн байна

ХОЁР. "БИ ДИ СЕК УЦК" ХК-НИЙ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

Тус компани нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримтална.

Даган мөрдөх тайлан

Санхүүгийн тайлангууд нь НББОУС-ын Хорооноос гаргаж мөрдүүлсэн СТОУС болон НББОУХ-ны тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг даган мөрдөнө.

Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайланг бэлтгэх зорилго нь байгууллагын хөрөнгө, эх үүсвэр, санхүүгийн байдал, хүлээн зөвшөөрсөн орлого, зарлага, тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үнэн зөв илэрхийлэх явдал юм.

Хэмжилтийн үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харах) бусад зүйлсийн хувьд өртөгт түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

- Санхүүгийн хэрэглүүр - Зээл ба авлага хорогдуулсан өртгөөр
- Санхүүгийн хэрэглүүр - Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн хэрэглүүр - Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн өр төлбөр - Санхүүгийн өр төлбөр хорогдуулсан өртгөөр

НББ-ийн ерөнхий суурь

Компанийн үйл ажиллагааны болоод тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг байна. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнасан.

Тасралтгүй үйл ажиллагааны төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд тулгуурлан бэлтгэгдсэн. Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг.

Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон тоног төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэл зэрэг элэгдүүлдэг хөрөнгөнүүдийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйн татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь идэвхтэй зах зээлийн мэдээлэл дээр үндэслэгдээгүй тохиолдолд тэдгээрийн бодит үнэ цэнийг үнэлгээний загваруудыг хамарсан янз бүрийн үнэлгээний арга техникүүдийг ашиглан тодорхойлно. Боломжтой бол идэвхтэй зах зээл дээрээс эдгээр загваруудад ашиглах мэдээллүүдийг авч үнэлэх ба ийм боломжгүй тохиолдолд бусад мэдээлэл ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлно. Идэвхтэй зах зээлийн болон бусад мэдээллүүд нь санхүүгийн байдлын тайланд тусгагдах санхүүгийн хөрөнгөнүүдийн бодит үнэ цэнийг тайлагнахад нөлөөлнө. Үнэлгээний загварууд нь боломжтой тохиолдолд ижил төрлийн хэрэглүүр дэх тухайн үеийн зах зээл дээрх ажиглагдаж байгаа мэдээллээс авсан үнээр төстлөгдөж баталгаажна.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгж тус бүрийн хувьд аливаа үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тодорхойлдог. Тухайн хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийг ашиглах ба худалдан борлуулснаас бий болох бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнээс бага байх тохиолдолд үнэ цэнийн бууралтыг авч үздэг.

Эрсдэлийн сан

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 507 тоот тогтоолоор батлагдсан "Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн тухай журам"-ын дагуу өөрсдийн харилцагч, хөрөнгө оруулагчдыг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийн гурваас доошгүй хувьтай тэнцэх хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах санг байгуулна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

Дансны авлага

Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

Бусад авлага

Бусад байгууллага, хууль хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг жилийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

Бараа материал

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

Тус компанийн хувьд үнэт цаасын төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй үнэ цааснууд бүртгэгдсэн.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон зээллэгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлыг тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн ангилал

Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна.

Үүнд:

- (а) Газрын сайжруулалт: Нийтийн эзэмшлийн газар дээр хийгдсэн явган хүний зам, ногоон байгууламж болон бусад газрын сайжруулалтууд;
- (б) Барилга байгууламж: Бүх төрлийн барилга, түүний бүрэлдэхүүнд хамаарах халаалт, ус, агааржуулалт, цахилгааны систем, зам, гүүр, яна бүрийн талбай зэрэг дэд бүтцийн шинжтэй зүйлс;
- (в) Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд;
- (г) Тээврийн хэрэгсэл: Бүх төрлийн тээврийн хэрэгсэлүүд;
- (д) Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгсэлүүд;
- (е) Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгсэлүүд;
- (ж) Бусад үндсэн хөрөнгө: Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгө хамаарна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу түүнийг захиргааны зорилгоор ашиглах нөхцөл хангагдсан үеэс эхлэн элэгдэл тооцно. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн аргуудаас хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжид үндэслэн сонгоно. Сонгосон аргыг тайлант үе бүрт тогтвортой мөрдөнө.

Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг (түүнийг бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд) ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнг санхүүгийн тайланд тодруулна.

Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

Биет бус хөрөнгийн хорогдол

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжид үндэслэн шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга эсхүл бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргуудаас аль нэгийг нь сонгон хэрэглэнэ.

Сонгосон хорогдуулалтын арга нь аж ахуйн нэгжийн хөрөнгөөс хүртэх эдийн засгийн үр өгөөжийг тодорхойлж чадахгүй байвал аж ахуйн нэгж нь шулуун шугамын аргыг хэрэглэнэ. Тодорхой ашиглалтын хугацаагүй биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдлын дүнг санхүүгийн тайланд тодруулна.

Өр төлбөр

Өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр гэж ангилна.

Богино хугацаат өр төлбөр

